



ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2019 оны 10 сарын 08 өдөр

Дугаар 8/164

Ховд

Г Албан тушаалын тодорхойлолт батлах тухай

Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4 дэх заалт, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам”-ын 5.1, Төрийн албаны зөвлөлийн “Зөвшөөрөл олгох тухай” 2019 оны 43 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн даргын албан тушаалын тодорхойлолтыг 1 дүгээр хавсралтаар, Хууль, эрх зүйн хэлтсийн даргын албан тушаалын тодорхойлолтыг 2 дугаар хавсралтаар, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн даргын албан тушаалын тодорхойлолтыг 3 дугаар хавсралтаар, Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргын албан тушаалын тодорхойлолтыг 4 дүгээр хавсралтаар, Нийгмийн бодлогын хэлтсийн даргын албан тушаалын тодорхойлолтыг 5 дугаар хавсралтаар, Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын хэлтсийн даргын албан тушаалын тодорхойлолтыг 6 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж, албан тушаалын тодорхойлолтыг мөрдүүлж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга / Б.Ганболд/-д даалгасугай.

ДАРГА

Д.ЭНХБОЛД



2019 тг. 8/164 Ch  
02 00307